



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



СТАТИСТИКИЙН ЭМХЭТГЭЛ

STATISTICAL YEARBOOK

2018



ГАРЧИГ

| | |
|---|---------|
| Товч танилцуулга..... | 1-27 |
| Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд..... | 28 |
| Нэг. Хүн ам..... | 29-37 |
| Хоёр. Эрүүл мэнд..... | 38-41 |
| Гурав. Боловсрол, соёл..... | 42-47 |
| Дөрөв. Хөдөлмөр эрхлэлт | 48-57 |
| Тав. Нийгмийн даатгал, халамж..... | 58-60 |
| Зургаа. Гэмт хэрэг..... | 61-64 |
| Долоо. Дотоодын нийт бүтээгдэхүүн | 65 |
| Найм. Мөнгө, зээл..... | 66 |
| Ес. Төсөв, санхүү | 67-68 |
| Арав. Үнэ | 69-74 |
| Арван нэг. Бизнес регистр..... | 75-77 |
| Арван хоёр. Хөдөө аж ахуй..... | 78-89 |
| Арван гурав. Аж үйлдвэр | 90-95 |
| Арван дөрөв. Барилга, орон сууц, нийтийн аж ахуй..... | 96-100 |
| Арван тав. Тээвэр, холбоо..... | 101-102 |
| Арван зургаа. Байгаль орчин | 103-106 |


ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2018 онд)


НЭГ. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**1.1.1 Хүн ам**

2018 оны эцэст 69.6 мянган байнгын оршин суугчтай болж 2017 оны жилийн эцсийн суурин хүн амын мэдээнээс 2.1 хувиар буюу 1368 хүнээр өссөн байна. 2000 оны хүн амын тооллогоос хойш жилд дунджаар 1.69 хувь буюу 19.0 мянган хүнээр, 2010 оны хүн амын тооллогоос хойш жилд дунджаар 2.31 хувь буюу 11.6 мянган хүнээр нэмэгджээ.

Зураг. Хүн амын тоо, өсөлтийн хувь, жил бүрийн эцэст



Зураг. Хүн амын жилийн дундаж өсөлт, сумаар, 2010-2018 онд




Дорноговь аймгийн хүн амын тоо 1979-1989 онд бүх сумдын хүн ам жигд өссөн, 1989-2000 оны хооронд Иххэт, Мандах, Сайхандулаан, Сайншанд сумдаас бусад 10 сумын хүн амын тоо, 2000-2010 онд Айраг, Даланжаргалан, Сайншанд, Замын-Үүд сумын хүн амын тоо өссөн байна. 2010-2018 онд Айраг, Хатанбулаг сумын хүн амын тоо 0.36-0.62 хувиар буурч, бусад сумдын хүн амын тоо жилд дунджаар 0.03-4.52 хувиар

өслөө. Замын-Үүд сумын хүн амын тооны өсөлт 2000-2010 онд жилд дунджаар 9.25 хувь, 2010-2018 онд 4.52 хувь буюу өсөлтийн хувь хамгийн өндөр сум хэвээр байна.


Дорноговь аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь 1969-1979 онд 3.25 хувиар өсч байсан нь хамгийн их өсөлттэй үе байсан бол 1989-2000 онд хүн амын тоо жилд дунджаар 1.10 хувиар буурч байв. 2010-2018 онд энэ үзүүлэлт 2.31 хувь болж өссөн байна.

Зураг. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь



Хүн амын нас, хүйсийн бүтцийг харуулах гол үзүүлэлтийн нэг бол нас, хүйсийн суварга билээ. 2010 онд манай аймгийн хүн амд 5-19 насныхны эзлэх хувь 2000 онтой харьцуулахад буурсан нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс төрөлт буурснаар тайлбарлагдаж байсан бол 2018 онд хадгалагдсан хэвээр 10-24 насны хүн амын нийт хүн амд эзлэх хувь бага байсаар байна.


Зураг. Дорноговь аймгийн хүн амын нас, хүйсний суварга



0-4 насны хүн амын эзлэх хувь 2010 оны мөн үетэй ойролцоо байгаа нь хүн амын нас хүйсийн суваргаас харагдаж байна. 2018 оны нас хүйсийн суваргаас харахад 0-4 насны болон 5-9 насны хүүхдийн эзлэх хувь өндөр байгааг сүүлийн 10 жилд төрсөн хүүхдийн тоо нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

Суурин хүн амын 50.2 хувь нь эрэгтэйчүүд, 49.8 хувь нь эмэгтэйчүүд юм. Нийт хүн амын 63.5 хувь нь хот (аймгийн төв), тосгонд, 13.9 хувь нь сумын төвд, 22.6 хувь нь хөдөөд амьдарч байна. Хот тосгонд амьдарч буй хүн амын тоо өмнөх оноос 0.4 пунктээр, сумын төвд амьдарч буй хүн амын тоо 0.2 пунктээр тус тус өсч, хөдөөд амьдарч буй хүн амын тоо 0.4 пунктээр буурчээ. 109.4 мянган кв.км нутаг дэвсгэрт 69.5 мянган хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 0.64 хүн ногдож байна. Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан сумын хүн амын нягтрал аймгийн дунджаас дээгүүр байна.

Зураг. Хүн амын насны бүтэц, хувиар 2000, 2010, 2018 он



Дорноговь аймгийн хүн амын тоонд насны ангилал тус бүрийн эзлэх хувийн жин 2018 онд 2000 оныхоос өөрчлөгдсөн байна. 2000 онд хүн амын 36.2 хувийг хүүхэд (0-14нас), 60.3 хувийг хөдөлмөрийн насны (15-64нас), 3.5 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзэлж байсан бол 2018 онд 31.5 хувийг хүүхэд, 62.3 хувийг хөдөлмөрийн

насны, 6.2 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзлэж байна. 2010 оны хүн амын орон сууцны тооллогын дүнтэй хүн амын тоонд насны ангилал тус бүрийн эзлэх хувийн жинг харьцуулахад 0-14 насны хүүхэд 1.9 пунктээр, тэтгэвэрийн насны хүн ам 1.4 пунктээр тус тус нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн ам 3.3 пунктээр буурлаа.

Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах, эдийн засгийн тодорхой ач холбогдолтой үзүүлэлт бол хүн ам зүйн ачаалал юм. Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцааг хүн ам зүйн ачаалал гэнэ. Хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настны тоо нь хүн амын нийгэм, эдийн засгийн чухал үзүүлэлтийн нэг юм. Хүн ам зүйн ачаалал 1979 онд 99.5 хувь, 1989 онд 90.9 хувь, 2000 онд 66.0 хувь, 2010 онд 48.8 хувьд хүрч тооллогоос тооллогын хооронд буурч байсан бол 2018 онд 53.9 болж нэмэгдсэн байна.

Зураг. Төрсөн хүүхэд, 2014-2018 он



2018 онд Дорноговь аймагт 829 хүү, 767 охин нийт 1596 шинэ хүн мэндэлж, 407 хүн нас барж хүн амын цэвэр өсөлт 1189 болжээ.

Өмнөх онтой харьцуулбал төрсөн хүүхдийн тоо 210(15.2)-аар, нас барсан хүний тоо 47(13.1)-оор өсчээ.

Төрсөн хүүхдийн хүйсний харьцаа 108.1 нас барсан хүний хүйсний харьцаа 156.0 байна. Хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо) 2018 онд 100.8 байгаа нь 2017 оны үзүүлэлтээс 0.8 пунктээр их байна.

Хүн амын шилжих хөдөлгөөн нь аймаг, сумын хүн амын тооны өсөлт, өөрчлөлтийг илэрхийлдэг үндсэн үзүүлэлтийн нэг юм. 2018 онд Дорноговь аймагт бүртгэлтэй шилжин ирсэн хүний тоо 1732, бүртгэлтэй шилжин явсан хүний тоо 1688 болж цэвэр шилжилт 44 байгаа нь өмнөх оноос 618-аар буурсан байна.

Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент 2012 онд -0.21, 2014 онд -0.12, 2015 -0.6 болж сөрөг урсгалтай гарч байсан бол 2011 онд 0.42, 2013 онд 0.19, 2016 онд 0.09, 2017 онд 0.97, 2018 онд 0.06 болж эерэг урсгалтай байна..

Шилжин явсан хүн амын 33.7 хувь Улаанбаатар хот, 8.5 хувь нь Говьсүмбэр аймаг, 6.8 хувь нь Сэлэнгэ аймаг, 6.5 хувь Дархан-Уул аймаг, 6.3 хувь нь Сүхбаатар аймаг руу, шилжин ирсэн хүн амын 34.2 хувь нь Улаанбаатар хот, 8.5 хувь Говьсүмбэр аймаг, 6.5 хувь Хэнтий аймаг, 6.5 хувь нь Сүхбаатар аймгаас тус тус шилжин ирж, явсан нь хамгийн өндөр хувь байна.




1.1.2. Өрхийн зарим үзүүлэлт

2018 оны эцэст 21286 өрхтэй болсон бөгөөд энэ нь өмнөх оныхоос 442(2.1%) өрхөөр нэмэгдэж нэг өрхөд ногдох хүний тоо 3.3 байна. 2018 онд нийт өрхийн 58.7 хувь нь аймгийн төв, тосгонд, 41.3 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байгаа нь хотожсон аймаг болохыг харуулж байна.


Дорноговь аймгийн хэмжээнд 2018 онд 834 өнчин хүүхэд байгаагийн 54(6.5%) нь бүтэн өнчин, 780(93.5%) нь хагас өнчин хүүхдүүд юм. Бүтэн өнчин хүүхэд 2018 онд өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд, хагас өнчин хүүхдийн тоо 32(4.3%)-оор өсчээ. нийт өнчин хүүхдийн 78(9.4%) нь 0-4 насны, 235(28.2%) нь 5-9 насны, 287(34.4%) нь 10-14 насны, 67(8.0%) нь 15 насны, 76(9.1%) нь 16 насны, 91(10.9%) нь 17 насны хүүхдүүд юм.

Зураг. Хагас, бүтэн өнчин хүүхдийн тоо, 2014-2018 он




Өрх толгойлсон эх 2018 онд 2001 болж, өмнөх оноос 266(11.7%)-аар, өрх толгойлсон эцэг 367 болж өмнөх оноос 35(8.7%)-аар тус тус буурчээ. Өрх толгойлсон эхчүүдийн 1071(53.5%) нь 3 хүртэлх, 812(40.6%) нь 3-5 гишүүнтэй, 118(5.9%) нь 6 түүнээс дээш гишүүнтэй өрхийг толгойлж байна.

Зураг.Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, гишүүдийн тоогоор, 2017-2018 он




Ганц биеэрээ амьдарч буй өндөр настай хүн 2018 оны эцэст 1053 болж өмнөх оноос 163(18.3%)-аар өссөн байна. Ганц биеэрээ амьдарч буй өндөр настай хүний 277(26.3%) нь эрэгтэйчүүд, 773(73.7%) нь эмэгтэйчүүд байна. Харин 18 хүртэлх насны 4 түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 734 болж, өмнөх оноос 48(6.1%)-аар буурчээ.

Зураг. 18 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо, хүүхдийн тоогоор, 2018 онд



Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2018 оны эцэст 2598 болж өмнөх оноос 46(1.8%)-аар өсчээ. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний 1003(38.6%) нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний 874(33.6%) нь төрөлхийн, 1724(66.4%) нь олдмол, үүнээс 66.1 хувь нь ердийн өвчний, 15.2 хувь нь ахуйн осол, 8.2 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөс, 8.0 хувь нь зам тээврийн ослоос, 2.4 хувь нь үйлдвэрийн ослын шалтгаантай байна.

Зураг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, 2009-2018 он




Хөгжлийн бэрхшээлтэй иргэний 28.3 хувь нь хөдөлгөөний, 28.0 хувь нь бусад хэлбэрийн, 18.4 хувь нь сэтгэцийн, 11.8 хувь нь харааны, 7.3 хувь нь сонсголын, 4.8 хувь нь хавсарсан, 3.5 хувь нь ярианы бэрхшээлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй 0-14 насны хүүхэд 2018 онд 208 болж өмнөх оноос 11(5.6%)-ээр нэмэгдэж, нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 8.0 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 0-14 настай хүүхдийн 74.0 хувь нь төрөлхийн, 26.0 хувь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна.




1.2 Эрүүл мэнд

2018 онд 353.7 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар, 17.0 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өсч, 13.1 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оноос 1.5 хувиар буурлаа.

Зураг. Урьдчилан сэргийлэх тарилга, мян.хүн



Зураг.Амбулаторийн үзлэг, мян.хүн



Энэ онд 1630 эх жирэмсний хяналтанд орсны 88.8 хувь буюу 1448 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ.

Түргэн тусламжийн дуудлага 19.7 мянган удаа гарсны 3.1 мянга буюу 15.7 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 4.3 хувиар, алсын дуудлага 1.5 хувиар тус тус өссөн байна.

Он гарсаар ослын улмаас 3016 хүн бэртэж, 107 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал ослын улмаас бэртсэн хүний тоо 17.1 хувиар, нас барсан хүний тоо 20-оор өссөн байна.

Халдварт өвчний 737 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс буюу 7.3 хувиар буюу 50-аар өсчээ.



1.3 Боловсрол

Бүх шатны сургуульд суралцагчид 2018/2019 оны хичээлийн жилд 14.2 мянгад хүрч, өмнөх оноос 0.2(1.2%) мянгаар нэмэгдсэн байна.

Ерөнхий боловсролын 22 сургуульд 2018/2019 оны хичээлийн жилд 13009 сурагч суралцаж байгаа нь өмнөх оноос 250(2.0%)-иар өссөн байна. Нийт суралцагчдын 56.0 хувь нь 1-5 дугаар ангид, 32.3 хувь нь 6-9 дугаар ангид, 11.7 хувь нь 10-12 дугаар ангид суралцаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 2018/2019 оны хичээлийн жилд 1621 хүүхэд элсэн орсон нь өмнөх оноос 68(4.4%)-аар нэмэгджээ. Дотуур байранд нийт 785 хүүхэд амьдарч байгаагаас 430(54.8%) нь эмэгтэй, 562(71.6%) нь малчдын хүүхэд байна.

2018/2019 оны хичээлийн жилд их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд 1143 оюутан суралцаж байгаа нь өмнөх оноос 81(6.6)-ээр буурчээ.

Аймгийн хэмжээнд 2018/2019 оны хичээлийн жилд 33 цэцэрлэгт, 5321 хүүхэд хүмүүжиж байгаа нь өмнөх оноос хүүхдийн тоо 0.6 хувиар буурч, цэцэрлэгийн тоо өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна. 2018-019 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх насны байгууллагын нэг багшид ногдох хүүхдийн 31 байгаа нь өмнөх оноос 1(2.4%)-ээр буурчээ.



1.4 Соёл

Мэргэжлийн урлагийн байгууллага нь 2018 онд шинээр 9 удаа уран бүтээл хийж, 184 удаагийн тоглолт хийсэн нь өмнөх оноос уран бүтээл 5-аар, тоглолтын тоо 28(17.9%)-аар тус тус өссөн байна. Нийт үзэгчдийн тоо 2018 оны эцэст 34.7 мянга байгаа нь өмнөх оноос 3.5 мянган хүнээр өсчээ.

Аймгийн хэмжээнд 2018 онд 14 музей үзвэрийн байгууллага үйл ажиллагаа явуулж, 10.4 мянган хүнд үйлчилсэн нь өмнөх оноос 2.8(36.8%) мянган хүнээр өссөн байна.

2018 онд аймгийн хэмжээнд 14 номын сан үйл ажиллагаа явуулж байгаагаас нийтийн номын сан 1 байна.



1.5.1 Хөдөлмөр

Энэ бүлэгт хөдөлмөрийн насны хүн ам, ажиллах хүч, ажиллагчид, бүртгэлтэй ажилгүй иргэд болон шинээр бий болсон ажлын байр, ажилд зуучлагдан орсон иргэдийн тухай мэдээллийг тусгалаа. Улсын хэмжээнд хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний мэдээ, тайлан гаргах судалгаа явуулахад ҮСХ-ны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд /хуучнаар/-ын 2009 оны 01/68/94 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг мөрдөж байна.

Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг ойлгоно. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 7 хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

Ажилгүй иргэн гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэд гэдэгт Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.


2018 онд хөдөлмөрийн насны (15 түүнээс дээш нас) хүн амын тоо 46529, үүнээс эдийн засгийн идэвхитэй хүн ам (ЭЗИХА)-ын тоо 31339 болж, өмнөх онтой харьцуулбал хөдөлмөрийн насны хүн амын тоо 3.0 хувиар, эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 6.3 хувиар буурчээ.

Хүйсийн хувьд эдийн засгийн идэвхтэй хүн амын 46.8 хувь нь буюу 14656 эмэгтэйчүүд байгаа нь эрэгтэйчүүдийн эдийн засгийн идэвхээс 6.4 пунктээр бага байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин 67.3 байгаа нь өмнөх оноос 2.4 пунктээр, 2015 оноос 0.7 пунктээр тус тус буурчээ.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувийг харуулдаг үзүүлэлт юм. 2018 оны дүнгээр хөдөлмөр эрхлэлтийн түвшин 63.8 хувь болж 2017 оны дүнгээс 1.7 пунктээр буурч, 2015 оны дүнгээс 5.3 пунктээр илүү байна.

Зураг: Хөдөлмөр эрхлэлтийн оролцооны түвшин, хүйсээр, оны эцэст



Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст 4121 төрийн албан хаагч ажиллаж байна. Нийт албан хаагчдын 3272 (79.4%) нь төрийн үйлчилгээний албан хаагч, 545 (13.2%) нь төрийн захиргааны албан хаагч, 196 (4.8%) нь төрийн тусгай албан хаагч, 108 (2.6%) нь улс төрийн албанд ажиллаж байна.



1.5.2 Ажилгүй иргэд

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны эцэст 993 болсны 964 (97.1%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 29 (2.9%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 32 (3.2%) хүнээр буурч, өмнөх сараас 248 (20.0%) хүнээр буурч 993 болсны 497 (50.1%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 438 (44.1%) нь Сайншанд суманд, 227 (22.8%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 641 (64.6%) нь бүрэн дунд, 153 (15.4%) нь дээд, 72 (7.3%) нь бүрэн бус дунд, 52 (5.2%) нь техник болон мэргэжлийн, 40 (4.0%) нь тусгай дунд, 24 (2.4%) нь боловсролгүй, 10 (1.0%) нь бага, 1 (0.1%) нь магистр/докторын зэрэгтэй иргэд эзэлж байна.

Зураг. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшинээр, дунд эзлэх хувиар, 2018 оны 12 дугаар сарын эцэст



64.6%
Бүрэн дунд

15.4%
Дипломын
болон
бакалаврын
дээд

7.3%
Суурь

5.2%
Техник
болон
мэргэжлийн

4.0%
Тусгай
мэргэжлийн
дунд

2.4%
Боловсролгүй

1.0%
Бага

0.1%
Магистр,
доктор

Зураг. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэн, ажилд зуучлагдан орсон хүний тоо, 2013-2018он



Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн насны бүтцийг авч үзвэл 34.2 хувийг 25-34 насныхан, 21.2 хувийг 15-24 насныхан, 26.3 хувийг 35-44 насныхан, 18.3 хувийг 45-60 насны иргэд байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 1158 ажлын байрны захиалгын 37.2 хувь нь уул уурхай олборлох аж үйлдвэр, 21.1 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 10.6 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 8.1 хувь нь барилга, 6.7 хувь нь боловсрол, 3.8 хувь нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ, 12.5 хувь нь бусад салбарын захиалга байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 1158 ажлын байрны 462 (39.9%) нь энгийн ажил, 163 (14.1%) нь мэргэжилтэн, 158 (13.6%) нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 97 (8.4%) нь техникч болон туслах / дэд мэргэжилтэн, 96 (8.3%) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 46 (4.0%) нь контор үйлчилгээ, 20 (1.7%) нь менежер, 116 (10.0%) нь бусад ажилтны захиалга байна.

Хөдөлмөрийн хэлтэст 2018 оны эцэст 1020 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 1098 иргэн ажилд зуучлагдан орж, 444 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.


Зураг. Шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд



2018 онд шинээр 1020 ажлын байр бий болгосны 746 (73.1%) нь байнгын ажлын байртай болжээ. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар үзвэл 34.4 хувь нь уул уурхай олборлолт, 13.7 хувь нь барилга, 13.5 хувь нь ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас

барилт, ан агнуур, 12.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 6.1 хувь нь боловсрол, 6.0 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 13.8 хувь нь бусад салбарт ногдож байна.


Зураг. Шинээр бий болсон ажлын байр, эдийн засгийн салбарын ангилалаар, 2018 онд



1.6 Нийгмийн даатгал, халамж

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 онд 33714.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4539.1 (15.6%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 онд өмнөх оны мөн үеэс 4539.1 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 3790.7(21.7%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 430.3 (21.8%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгал 632.0 (21.8%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 177.2(22.1%) өссөн нь нөлөөлсөн байна.


Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2018 оны эцэст



Нийгмийн даатгалын сангийн зарлага 43933.8 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2964.1 (7.2%) сая.төгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 32887.0 (74.9%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2449.2 (5.6%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5220.3 (11.9%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын

сангаас 2514.0 (5.7%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 863.3 (2.0%) сая төгрөгийг зарцуулжээ.


Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2018 онд нийгмийн халамжийн сангаас 30670 иргэнд 8064.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 12196 (66.0%)-оор өсч, олгосон тэтгэвэр тэтгэмж 2094.8 (35.1%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. 2018 онд цалинтай ээж хөтөлбөрийн хүрээнд 1664.9 сая төгрөгийг 3769 эхэд олгосон нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж өсөхөд нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2018 онд 1376 хүн хамрагдсан нь өмнөх оноос 64 (4.4%)-өөр буурч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 283.6 (13.9%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 1079 иргэнд 774.2 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 1024 иргэнд 653.1 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 368 иргэнд 30.8 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 15572 иргэнийг хамруулж, 1369.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 11251 иргэн хамрагдаж, 2914.6 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо




Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/



1.7.1 Гэмт хэрэг


Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2018 онд 517 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 150 хүн гэмтэж, 27 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 137 (20.9%)-оор, гэмтсэн хүний тоо 63 (29.6%) -аар буурч, нас барсан хүний тоо 1 (3.8%)-ээр нэмэгдсэн байна.

Зураг. Гэмт хэргийн улмаас гэмтэж бэртсэн, нас барсан хүний, жил бүрийн оны эцэст



Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 62 (22.1%)-оор, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 28 (16.4%)-аар, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 22 (45.8%)-оор, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 17 (28.8%)-оор, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 15 (60.0%)-аар, хүний амины гэмт хэрэг 10 (55.6%)-аар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 5 (50.0%)-аар, авилгын гэмт хэрэг 2 (33.3%)-оор буурч бусад төрлийн гэмт хэрэг нэмэгджээ.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 42.4 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 27.7 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 8.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 21.8 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 70 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 87 (55.4%)-оор буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Алтанширээ, Даланжаргалан, Мандах, Улаанбадрах, Хөвсгөл сумдад нэмэгдэж, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 2301.0 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2121.3 (47.9 %) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 728.3 (31.6%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 139 (26.9%) нь гэр орон сууцандаа, 87 (16.8%) нь гудамж олон нийтийн газарт, 70(13.5%) нь согтуугаар, 28 (5.4%) бүлэглэн, 73(14.2%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 191 (36.9%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 1455 хүн саатуулагдаж, 278 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2018 оны эцэст



1.7.2 Гал түймэр

Аймгийн хэмжээнд 2018 онд их бага хэмжээний 34 гал түймэр гарч, 103.2 сая.төг-ийн хохирол учирсан байна. Гарсан гал түймрийн тоо 37.0 хувиар, учирсан хохирлын хэмжээ 45.3 хувиар буурсан байна.

Нийт гарсан гал түймрийн 32.3 хувь нь ил задгай гал, лаа, шүдэнз, тамхины галаас, 38.2 хувь нь цахилгаан угсралт, ашиглалтын буруугаас, 8.8 хувь нь пийшин зуухны зөрчлөөс, 5.9 хувь нь техникийн гэмтэлээс, 11.8 хувийн нөхцөл шалтгаан тогтоогдоогүй байна.

Тайлант онд 252 аж ахуйн нэгж, байгууллага, 5810 айл өрхөд гал түймрээс урьдчилан сэргийлэх үзлэг явуулсан нь өмнөх оны мөн үеэс аж ахуйн нэгж, байгууллагын тоо 35.9 хувиар, айл өрхийн тоо 8.8 хувиар тус тус буурчээ.

ХОЁР. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ




2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) тооцоог 2007 оноос Сангийн сайд, ҮСГ-ын даргын 2006 оны 129\376 тоот тушаалаар батлагдсан эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын шинэчилсэн ангилалын дагуу 19 салбараар тооцож байна.

2017 онд ДНБ 297.4 тэрбум төгрөг /оны үнээр/ болж 2016 оныхоос 9.2 хувиар буюу 25.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 16.0 хувиар, үйлдвэрлэлийн салбар 4.8 хувиар, үйлчилгээний салбар 7.6 хувиар тус тус өслөө. Нэг хүнд ногдох ДНБ 2017 онд 4412.7 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 214.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

Зураг. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, мян төгрөгөөр




ДНБ-ийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 80.7(27.0%) тэрбум төгрөгийг хөдөө аж ахуй, 51.6(17.4%) тэрбум төгрөгийг аж үйлдвэр, барилга, 165.1(55.6%) тэрбум төгрөгийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэжээ.




2.2 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 1431,6 тэрбум төгрөг болж өмнөх оноос 274.6 (23.7%) сая төгрөгөөр, цэвэр зарлага 1363,9 тэрбум төгрөг болж 270.61(24.7%) сая төгрөгөөр тус тус өссөн байна

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2017-2018 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2017-2018 он, сая.төг






Иргэдийн мөнгөн хадгаламж 108.2 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1503.2 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1587.0 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 5.0 (7.5%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 29.3 (37.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 12 дугаар сарын эцэст 1935.8 сая төгрөг болж, өмнөх сараас 683.3(26.2%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1450.3(42.8%) сая төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж, өмнөх сараас 0.3 пунктээр, өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр тус тус буурчээ.

Чанаргүй зээл 12 дугаар сарын эцэст 6934.2 сая төгрөг болж өмнөх сараас 308.0 (4.3%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 197.9 (2.9%) сая төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 3.3 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018 оны эцэст



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018 оны эцэст






2.3 Төсөв, санхүү

2018 оны 12 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 28466.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 102.3 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 16.1 хувиар буурсан байгаа нь улсын төсвөөс санхүүждэг тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих зардлын эх үүсвэрүүд 2017 оноос орлогын гүйцэтгэлийн дүнд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой юм. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 77.0 хувийг татварын, 23.0 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2018 оны 12-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 6153.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 964.3 (18.6%) сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 1459.8 (31.1 %) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.4 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2018 оны 12 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 0.3 хувь, өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.3 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.7 хувь, хувцас бөс бараа, гутал 0.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 12 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)




Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 10.5 хувь, согтууруулах ундаа, тамхи 3.2 хувь, хувцас бөс бараа, гутал 4.7 хувь, гэр ахуйн тавилга 2.7 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ 12.7 хувь, тээвэр 8.8 хувь, амралт чөлөөт цаг соёлын бараа 1.6 хувь, боловсролын үйлчилгээ 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээ 4.4 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 5.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017 - 2018 оны сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017-2018 оны 1-12 сарын үнийн өөрчлөлт (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2014 -2018 оны 12 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



3.1 Бизнес регистр

Статистикийн бизнес регистрийн санд 2018 оны жилийн эцсийн байдлаар 1597 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагийн 1161 (72.7%) нь хэвийн үйл ажиллагаа явуулж, 436 (27.3%) нь үйл ажиллагаа эхлээгүй, түр зогссон, бүрэн зогсоосон болон бусад шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй байна. 2018 онд 162 аж ахуй нэгж шинээр байгуулагдаж, 50 аж ахуйн нэгж шилжсэн болон татан буугдсан байна.

Өмнөх онтой харьцуулахад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 11.0 хувиар нэмэгдэж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн эзлэх хувь өмнөх оноос 1.6 пунктээр буурчээ.

Зураг. Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо, үйл ажиллагааны эрхлэлтийн байдлаар

Бүгд 1597



1161
Үйл ажиллагаа
явуулж байгаа




Нийт аж ахуйн нэгжийн 26.9 хувь нь худалдааны салбарт, 17.5 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 5.9 хувь нь санхүүгийн гүйлгээ хийх салбарт 5.9 хувь нь зочид буудал, зоогийн газрын салбарт бүртгэлтэй байна.

Өмнөх оноос мэдээлэл холбооны салбарын аж ахуйн нэгжийн тоо 3.4 хувиар буурч, бусад салбарын аж ахуйн нэгжийн тоо 1.5-94.4 хувиар нэмэгджээ.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 935 (80.5%) нь 1-9 ажиллагчтай, 103 (8.9%) нь 10-19 ажиллагчтай, 90(7.8%) нь 20-49 ажиллагчтай, 33(2.8%) нь 50-с дээш ажиллагчтай аж ахуйн нэгж эзэлж байна. Өмнөх оноос 1-9 ажиллагчтай аж ахуйн нэгж байгууллагын тоо 2.3 пункт, 20-49 ажиллагчтай аж ахуйн нэгж байгууллагын тоо 1.5 пункт, 10-19 ажиллагчтай аж ахуйн нэгж байгууллагын тоо 1.1 пункт, 50-с дээш ажиллагчтай аж ахуйн нэгж байгууллагын тоо 0.5 пунктээр тус тус нэмэгджээ.

Зураг. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо, ажиллагчдын тооны бүлгээр






3.2 Хөдөө аж ахуй

2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 2148.1 мянган толгой мал тоологдсоны дотор 42.8 мянган тэмээ, 139.9 мянган адуу, 80.6 мянган үхэр, 926.2 мянган хонь, 958.6 мянган ямаа тоологджээ. Нийт малын тоо өмнөх оноос 7.3 хувь буюу 146.5 мянган толгойгоор өсчээ. Мал сүргийн тоог таван төрлөөр авч үзвэл 6758 (5.1%) адуугаар, 2088 (5.1%) тэмээгээр, 64985 (7.3%) ямаагаар, 64702 (7.5%) хониор, 7956 (11.0%) үхрээр тус тус өссөн байна.

Жил бүрийн эцсийн мал тооллогын дүнг харахад аймаг байгуулагдсан 1931 оноос нэг саяас дээш мал тоолуулсан 25 дахь жил, хоёр сая мал тоолуулсан 2 дахь жил байлаа.

Зураг . Нэг саяас дээш толгой мал тоолуулсан он, малын тоо, мянган.толгой



Сүргийн бүтцэд ямаа 44.6 хувийг, хонь 43.1 хувийг, үхэр 3.8 хувийг, адуу 6.5 хувийг, тэмээ 2.0 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад үхэр, хонины эзлэх хувь 0.1 пунктээр өсч, адууны эзлэх хувь 0.1 пунктээр буурч, тэмээ, ямааны эзлэх хувь өмнөх онтой адил байна.


Аймгийн хэмжээгээр 1000–аас дээш малтай өрхийн тоо 445 болж өмнөх оноос 35 өрхөөр өсчээ. 1000 –аас дээш малтай өрх Сайхандулаан суманд 60, Дэлгэрэх суманд 51, Даланжаргалан суманд 37, Иххэт, Өргөн сумдад тус тус 36, Хатанбулаг суманд 35 тоологдсон нь хамгийн олон нь байсан бол 2001-ээс дээш малтай өрх Дэлгэрэх, Өргөн сумдад тус бүр 5 өрх, Айраг, Иххэт сумдад тус бүр 4 өрх, Сайхандулаан, Мандах сумдад тус бүр 2 өрх, Замын-Үүд, Алтанширээ, Хөвсгөл, Сайншанд сумдад тус бүр 1 өрх тоологджээ.

Аминдаа малтай 5288 өрх байгаагийн 80.1 хувь буюу 4234 нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж байгаа малчин өрх байна. Малчин нэг өрхөд 468, малтай нэг өрхөд 400 толгой мал ногдож байгаа нь 2017 оноос малчин нэг өрхөд ногдох мал 25 толгой, малтай нэг өрхөд ногдох мал 21 толгой малаар нэмэгджээ. Малчдын тоо 2018 онд 7033 болж өмнөх оноос 199 (3.0%)–аар буурчээ.

2018 онд оны эхний нийт хээлтэгч малын 672.2 (79.5%) мянган эх мал төллөж, гарсан төлийн 659.7 (96.3%) мянган төл бойжуулжээ. Үүнийг өмнөх онтой харьцуулахад бойжсон төл 0.6 хувиар өссөн байна.

2018 онд 18.9 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь оны эхний малын 0.9 хувьтай тэнцэж байна. Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Хатанбулаг, Хөвсгөл сумдад хорогдсон малын тоо нийт хорогдлын 69.7 хувийг эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, мянган толгойгоор, 2000-2018 он



Энэ онд 25 худаг шинээр гаргахад 440.0 сая төгрөг, 151 худаг сэргээн засварлахад 115.4 сая төгрөг зарцуулсан байна.

Малжуулах арга хэмжээнд 104 өрхийг хамруулж нийт 8929 толгой мал олгосны 98.3 хувь нь бог мал байв. Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо өмнөх оныхтой адил, нэг өрхөд дундажаар 86 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 15 толгойгоор нэмэгдсэн үзүүлэлт байна.

Нийт малчин өрхийн 78.4 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 70.6 хувь нь телевизортэй, 53.8 хувь нь автомашинтай, 61.5 хувь нь мотоциклтой өрх байна. Өмнөх оныхоос цахилгааны эх үүсгүүртэй өрх 4.0 пункт, телевизортэй өрх 0.1 пунктээр тус тус буурч, автомашинтай өрх 3.1 пункт, мотоциклтой өрх 3.2 пунктээр тус тус өссөн байна.

2018 онд 22.5 га талбайд төмс, 56.0 га-д хүнсний ногоо тариалж, 93.9 тн төмс, 234.5 тн хүнсний ногоо хураан авлаа. Өмнөх оныхоос хураан авсан төмс 6.4 тн-оор, хүнсний ногоо 112.0 тн-оор тус тус буурсан байна. 1 га-аас 4.2 тонн төмс, хүнсний ногоо хураан авсан нь 2017 оноос төмс 1.0 тн-оор нэмэгдэж, хүнсний ногоо 0.9 тн-оор буурчээ. Тайлант онд 5724.5 тн өвс хадлан, 492.1 тн гар тэжээл, 548.1 тн хужир шүү тэжээл бэлтгэсэн мэдээ ирүүлснийг өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 5.1 хувиар нэмэгдэж, гар тэжээл 8.4 хувиар, хужир шүү 41.9 хувиар тус тус буурчээ.



3.3 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эцэст 230.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 68.5(42.2%) тэрбумаар өссөн байна. Үүнд уул уурхайн салбарын үйлдвэрлэлт 55.1 хувиар, боловсруулах салбарын үйлдвэрлэл 27.8 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл 38.0 хувиар тус тус өсчээ.

Зураг. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл. сая төг



Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 4.0 хувь, компани 95.7 хувь, өрхийн аж ахуй 0.3 хувийг тус тус үйлдвэрлэжээ.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өмнөх оны мөн үетэй харьцуулахад сувагжуулалт 91.2 мян.м3-аар, дулаан 9.1 мян.ккал-аар, ус түгээлт 102.0 мян.м3-аар, нарийн боов 25.0 тонноор, бялуу 1.2 тонноор, хэвийн боов 0.4 тонноор, хиам 1.3 тонноор, шингэн сүү 8.3 мян.литр-ээр, тараг 3.7 мян.литр-ээр, 0.6 тонноор, ногоон цай/загсгал цай/ 147.5 кг-аар, вакуум цонх 321.2 м2-аар, хайрга 15.2 мян.м3-ээр, бетон зуурмаг 7018.4 м3-ээр, цемент 318.2 мян.тн-оор, гөлтгөнө 7249 тонноор, замын хавтан хашлага 1721.4 м2-аар, оёдол 26616.8 мян.төгрөгөөр, модон эдлэл 43167.4 мян.төгрөгөөр, нүүрс 168.9 мян.тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.



3.4.1 Барилга угсралт, их засвар

2018 онд нийт 423234.8 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэн байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 1.7 хувийг улсын төсвийн, 1.6 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Зураг. Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, сая төг



Барилга угсралт их засварын ажлын 4.8 хувь нь орон сууцны барилга, 16.5 хувь нь орон сууцны бус барилга, 77.8 хувь нь инженерийн барилга, байгууламж, 1.0 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны барилгын эзлэх хувь 16.7 пунктээр, орон сууцны бус барилгын эзлэх хувь 16.2 пунктээр, их засварын ажлын эзлэх хувь 1.6 пунктээр буурч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 34.6 пунктээр өссөн байна.


3.4.2 Орон сууц, нийтийн аж ахуй

2018 онд нийт 19.7 мян.м² талбай бүхий орон сууцыг шинээр ашиглалтанд оруулснаар 338 өрх, 1149 хүн шинэ сууцаар хангагджээ. Ашиглалтанд оруулсан орон сууцны талбайг 2017 онтой харьцуулбал 5.2 хувиар нэмэгдсэн байна.

2018 онд хот сууринд гүний худаг 47, ус түгээх цэг 65, цэцэрлэгт хүрээлэн 23, хөшөө баримал 91, гэрэлтүүлэгтэй гудамж талбай 106 км болжээ.

Өмнөх оноос халуун усны газар 5-аар, хог тээврийн машины тоо 2-оор нэмэгдсэн байна.

Зураг. Ашиглалтанд оруулсан орон сууц, өрх, хүн амын тоогоор



3.5 Тээвэр, Холбоо

2018 онд 184.9 мянган тонн ачаа тээвэрлэж, 59936.2 мянган тонн км-ын ажил, 108.2 мянган зорчигч тээвэрлэж, 18028.0 мянган хүн,км-ын ажил гүйцэтгэсэн байна. Тээвэрлэлтийн нийт орлого 10620.3 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 8.4 хувиар нэмэгдсэн байна.

2018 онд хийгдсэн тээврийн хэрэгслийн техникийн хяналт оношлогооны мэдээгээр тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд 17910 авто машин, тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь өмнөх оноос 34.0 хувь буюу 4.5 мянгаар нэмэгджээ. Нийт тээврийн хэрэгслийн 88.4 хувийг автомашин, 6.0 хувийг мотоцикл, 5.3 хувийг чиргүүл эзэлж байна. Харин 2018 оны жилийн эцсийн мал тооллогоор малчин өрхүүдэд тоологдсон мотоциклын тоог техникийн хяналт оношлогооны дүнтэй харьцуулж үзэхэд аймгийн хэмжээний 2 мотоцикл тутмын 1 нь улсын дугаар авч тээврийн хэрэгслийн санд бүртгэгдсэн байна.

Шуудан холбооны үйлчилгээний орлого 518.1 сая төгрөг болж өмнөх оноос 64.5 хувиар буурсан байна. Суурин телефон цэгийн тоо 2018 онд 1864 болж өмнөх оноос 7.4 хувиар буюу 150 хэрэглэгчээр буурсан байна. Энэ онд нийт 10.7 мянган ширхэг албан

бичиг, захидал 2.5 мянган ширхэг, 864 ширхэг илгээмж (боодол) илгээж, 32.9 сая төгрөгийн орлого оруулжээ.

Аймгийн хэмжээнд 2 кабелийн болон эфирийн телевиз 1600 гаруй хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж, нийт 112.5 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Байршлаар нь авч үзвэл Сайншанд суманд 1, Замын-Үүд суманд 1 кабелийн телевизийн цэг ажиллаж байна.

2018 онд Дорноговь аймагт үүрэн телефоны оператор 4 компанийн салбар ажиллаж байгааг байршлаар авч үзвэл юнителын 15, мобикомын 15, скайтелын 13, G-mobile 12, суурин телефон цэг 7 суурин газарт нийт 62 салбар нэгж сум, суурин газруудад үйлчилгээ үзүүлжээ. Үүрэн телефоны салбарууд энэ онд нийт 6700.0 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оныхоос 1 дахин өссөн байна. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (давхардсан тоогоор) 102.0 мянга орчим байгаа нь өмнөх оноос 20.6 мянган хэрэглэгчээр нэмэгдсэн байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



4.1.1 Байгаль орчин

Цаг уур

2018 оны 12 дугаар сард Сарын дундаж агаарын температур Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах сумдад 13.4-14.3 хэм хүйтэн, Дэлгэрэх, Алтанширээ сумдад 17.0-17.7 хэм хүйтэн, бусад сумдын нутгаар 15.2-16.9 хэм хүйтэн, агаарын температур өдөртөө Дэлгэрэх, Иххэт сумдад 2-4 хэм дулаан, бусад сумдын нутгаар 9-11 хэм дулаан, шөнөдөө 29-34 хэм хүйтэн байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Сайншанд, Мандах, Хөвсгөл, Дэлгэрэх, Алтанширээ, Эрдэнэ сумдад ОЖД-аас хүйтэн, бусад сумдын нутгаар ОЖД-ийн орчим байлаа.

Энэ сард салхины хамгийн их хурд Эрдэнэ суманд 25 м/с, Хөвсгөл суманд 22 м/с, Сайншанд, Замын-Үүд, Мандах сумдад 18-20 м/с, Дэлгэрэх, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг сумдад 16-17 м/с хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна. Өргөн суманд салхины хурд 10 м/с хүрээгүй, бусад сумдын нутгаар 10 м/с-ээс дээш салхитай хоногийн тоо 1-18 өдөр байв.

12 дугаар сард Замын-Үүд суманд 1 өдөр 0.3 мм цас орж бусад сумдын нутгаар цасгүй байв.

4.1.2 Байгаль орчин

Дорноговь аймгийн нийт газар нутгийн 85.9 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 10.3 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 1.4 хувийг ойн сан бүхий газар, 1.6 хувийг хот, тосгон, суурин газар, 0.6 хувийг зам, шугам сүлжээний газар, 0.2 хувийг усан сан бүхий газар эзэлж байна.

2018 онд аймгийн нийт газар нутгийн 2770.7(0.02%) га газарт ямар нэг хэмжээний хохирол учруулжээ. Үүний 698.8 (25.2%) га газар бэлчээр ба бусад өвслөг ургамал газар байна.



24.8 га газарт нөхөн сэргээлтийн ажил хийсэн бөгөөд үүнд 50.0 сая төгрөгийн зардал гаргажээ.

Аймгийн хэмжээнд 2018 онд 33.0 мянган ширхэг мод тарьснаас 80.0 хувь нь ургасан байна.

Газар өмчлөх хүсэлт ирүүлсэн өрхийн 2218 (96.4%)-д газар өмчлүүлэх шийдвэр гаргасан ба гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэдэд өмчлүүлсэн газрын хэмжээ 347.96 га болж өмнөх оноос 5 дахин нэмэгджээ.

Аймгийн хэмжээнд тусгай хамгаалалтай 115 газар бүртгэлтэй байгаагийн 104 (90.4%) газар нь аймаг, сумын тусгай хамгаалалтай газар байна. Өмнө онтой харьцуулахад аймгийн тусгай хамгаалалтай газар 2.4 дахин, сумын тусгай хамгаалалтай 4.3 дахин нэмэгджээ.

_____ о О о _____



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2015-2018 он)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

| | Хэмжих нэгж | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2018 2017 |
|--|-------------|---------|---------|----------|----------|------------------|
| 1. Бэлэн хүн ам, мян.хүн | мян.хүн | 63.1 | 66.6 | 68.2 | 69.6 | 102.1 |
| - Төрсөн хүүхдийн тоо | тоо | 1667 | 1527 | 1386 | 1596 | 115.2 |
| - Нас барсан хүний тоо - бодит тоогоор** | тоо | 350 | 391 | 360 | 407 | 113.1 |
| - Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор | тоо | 1317 | 1136 | 1026 | 1189 | 115.9 |
| - Нялхасын эндэгдэл - бодит тоогоор | тоо | 20 | 19 | 17 | 16 | 94.1 |
| - 1000 хүүхдэд ноогдох | тоо | 12.0 | 11.4 | 12.3 | 10.0 | 81.7 |
| 2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд | тоо | 1 227 | 1 503 | 1 025 | 993 | 96.9 |
| - Үүнээс эмэгтэй | тоо | 713 | 811 | 530 | 497 | 93.8 |
| - Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо | тоо | 307 | 354 | 237 | 230 | 96.9 |
| 3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд | тоо | 1075 | 459 | 810 | 1020 | 125.9 |
| Үүнээс: Байнгын ажлын байр | тоо | 876 | 349 | 580 | 746 | 128.6 |
| Улирлын чанартай ажлын байр | тоо | 199 | 110 | 230 | 274 | 119.1 |
| 4. Суралцагсад-Бүгд | хүн | 13363 | 13586 | 13983 | 14152 | 101.2 |
| Үүнээс: ЕБС-д | хүн | 11895 | 12278 | 12759 | 13009 | 102.0 |
| МСҮТ-д | хүн | 654 | 623 | 597 | 577 | 96.6 |
| ЭМШУИС-ийн салбар сургуульд | хүн | 846 | 685 | 627 | 566 | 90.3 |
| 5. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор | тоо | 883 | 1742 | 687 | 737 | 107.3 |
| - 10000 хүнд ногдох | тоо | 139 | 262 | 101 | 106 | 105.0 |
| 6. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор | тоо | 561 | 665 | 654 | 517 | 79.1 |
| - 10000 хүнд ногдох * | тоо | 139 | 155 | 149 | 117 | 79.1 |
| 7. Малын тоо | мян.тол | 1801.2 | 1752.9 | 2001.6 | 2147.2 | 107.3 |
| - Бүгд | мян.тол | 1801.2 | 1752.9 | 2001.6 | 2147.2 | 107.3 |
| - Тэмээ | мян.тол | 36.1 | 37.7 | 40.7 | 42.8 | 105.2 |
| - Адуу | мян.тол | 131.6 | 118.7 | 133.2 | 139.9 | 105.0 |
| - Үхэр | мян.тол | 69.9 | 63.0 | 72.6 | 80.5 | 110.9 |
| - Хонь | мян.тол | 751.4 | 758.4 | 861.5 | 925.8 | 107.5 |
| - Ямаа | мян.тол | 812.2 | 775.2 | 893.6 | 958.2 | 107.2 |
| 8. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн | сая төг | 10509.3 | 35998.5 | 162252.1 | 230744.1 | 142.2 |
| Борлуулсан бүтээгдэхүүн | сая төг | 12141.8 | 55132.1 | 273507.2 | 339177.4 | 124.0 |
| 9. Их барилга | | | | | | |
| -Нийт барилга угсралт | сая төг | 42185.2 | 17046.2 | 111924.1 | 423234.8 | 3.8 ² |
| - Үүнээс. их засвар | сая төг | 1054.7 | 483.7 | 4880.7 | 4120.4 | 84.4 |

* - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.

²- Дахин их

...-мэдээлэл байхгүй



**II.ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН
ТУХАЙ СТАТИСТИКИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ**
(Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

НЭГ.ХҮН АМ

1.1 СУУРИН ХҮН АМЫН ТОО, хүйс байршлаар, мян.хүн, оны эцэст

| | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2018 2013 | 2018 2017 |
|------------------------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|--------------|--------------|
| Суурин хүн ам, хүйсээр | | | | | | | | |
| Бүгд | 62.5 | 63.5 | 63.1 | 66.6 | 68.2 | 69.6 | 111.4 | 102.1 |
| үүнээс: -эрэгтэй | 31.2 | 31.7 | 31.5 | 33.3 | 34.1 | 34.9 | 112.0 | 102.3 |
| -эмэгтэй | 31.3 | 31.8 | 31.6 | 33.3 | 34.1 | 34.7 | 110.8 | 101.8 |
| Хүйсний харьцаа | 99.5 | 99.9 | 99.7 | 100.0 | 100.0 | 100.6 | | |
| Хот, хөдөөгийн хүн ам | | | | | | | | |
| - хот, сууринд | 37.9 | 39.0 | 38.9 | 41.6 | 43.0 | 44.2 | 116.7 | 102.8 |
| - хөдөөд | 24.6 | 24.5 | 24.2 | 25.0 | 25.2 | 25.4 | 103.2 | 100.8 |
| Жилийн дундаж хүн ам | | | | | | | | |
| Бүгд | 61.7 | 63.0 | 63.3 | 64.9 | 67.4 | 68.9 | 111.7 | 102.2 |
| үүнээс: -эрэгтэй | 30.8 | 31.4 | 31.6 | 32.4 | 33.7 | 34.5 | 112.0 | 102.4 |
| -эмэгтэй | 30.9 | 31.5 | 31.7 | 32.5 | 33.7 | 34.4 | 111.3 | 102.1 |

1.2 СУУРИН ХҮН АМЫН ТОО, насны бүлэг, хүйсээр, оны эцэст

| Насны бүлэг | 2015 | | 2016 | | 2017 | | 2018 | |
|-------------|--------------|-------------------|--------------|-------------------|--------------|-------------------|--------------|-------------------|
| | Бүгд | үүнээс эмэгтэй | Бүгд | үүнээс эмэгтэй | Бүгд | үүнээс эмэгтэй | Бүгд | үүнээс эмэгтэй |
| | ТОО | | | | | | | |
| Бүгд | 63125 | 31623 | 66606 | 33304 | 68192 | 34076 | 69560 | 34644 |
| 0-4 | 8145 | 3954 | 8120 | 3907 | 8049 | 3844 | 8204 | 3909 |
| 5-9 | 6630 | 3251 | 7123 | 3485 | 7481 | 3686 | 7837 | 3806 |
| 10-14 | 4960 | 2510 | 5180 | 2600 | 5442 | 2696 | 5897 | 2919 |
| 15-19 | 4935 | 2471 | 5155 | 2614 | 5222 | 2661 | 5143 | 2584 |
| 20-24 | 5305 | 2565 | 5302 | 2587 | 5176 | 2541 | 5154 | 2573 |
| 25-29 | 6235 | 3044 | 6514 | 3163 | 6535 | 3173 | 6165 | 2980 |
| 30-34 | 5593 | 2645 | 6095 | 2918 | 6299 | 3002 | 6439 | 3101 |
| 35-39 | 4868 | 2360 | 5234 | 2497 | 5330 | 2538 | 5367 | 2514 |
| 40-44 | 4124 | 2090 | 4637 | 2324 | 4766 | 2382 | 4796 | 2404 |
| 45-49 | 3534 | 1829 | 3718 | 1921 | 3831 | 1966 | 3998 | 1987 |
| 50-54 | 3022 | 1593 | 3273 | 1717 | 3349 | 1763 | 3401 | 1796 |
| 55-59 | 2362 | 1303 | 2514 | 1367 | 2697 | 1448 | 2869 | 1531 |
| 60-64 | 1327 | 710 | 1562 | 850 | 1700 | 953 | 1872 | 1044 |
| 65-69 | 748 | 426 | 824 | 458 | 933 | 514 | 1017 | 569 |
| 70-89 | 1296 | 840 | 1312 | 862 | 1340 | 875 | 1356 | 891 |
| 90+ | 41 | 32 | 43 | 34 | 42 | 34 | 45 | 36 |
| 0-14 нас | 19735 | 9715 | 20423 | 9992 | 20972 | 10226 | 21938 | 10634 |
| 15-59 нас | 39978 | 19900 | 42442 | 21108 | 43205 | 21474 | 43332 | 21470 |
| 60+ | 3412 | 2008 | 3741 | 2204 | 4015 | 2376 | 4290 | 2540 |



1.3 СУУРИН ХҮН АМЫН НАС, ХҮЙСНИЙ БҮТЭЦ, хувиар, оны эцэст

| насны бүлэг | 2015 | | 2016 | | 2017 | | 2018 | |
|-------------|--------------|-------------------|--------------|-------------------|--------------|-------------------|--------------|-------------------|
| | Бүгд | үүнээс эмэгтэй | Бүгд | үүнээс эмэгтэй | Бүгд | үүнээс эмэгтэй | Бүгд | үүнээс эмэгтэй |
| | хувь | | | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 0-4 | 12.9 | 12.5 | 12.2 | 11.7 | 11.8 | 11.3 | 11.8 | 11.3 |
| 5-9 | 10.5 | 10.3 | 10.7 | 10.5 | 11.0 | 10.8 | 11.3 | 11.0 |
| 10-14 | 7.9 | 7.9 | 7.8 | 7.8 | 8.0 | 7.9 | 8.5 | 8.4 |
| 15-19 | 7.8 | 7.8 | 7.7 | 7.8 | 7.7 | 7.8 | 7.4 | 7.5 |
| 20-24 | 8.4 | 8.1 | 8.0 | 7.8 | 7.6 | 7.5 | 7.4 | 7.4 |
| 25-29 | 9.9 | 9.6 | 9.8 | 9.5 | 9.6 | 9.3 | 8.9 | 8.6 |
| 30-34 | 8.9 | 8.4 | 9.2 | 8.8 | 9.2 | 8.8 | 9.3 | 9.0 |
| 35-39 | 7.7 | 7.5 | 7.9 | 7.5 | 7.8 | 7.4 | 7.7 | 7.3 |
| 40-44 | 6.5 | 6.6 | 7.0 | 7.0 | 7.0 | 7.0 | 6.9 | 6.9 |
| 45-49 | 5.6 | 5.8 | 5.6 | 5.8 | 5.6 | 5.8 | 5.7 | 5.7 |
| 50-54 | 4.8 | 5.0 | 4.9 | 5.2 | 4.9 | 5.2 | 4.9 | 5.2 |
| 55-59 | 3.7 | 4.1 | 3.8 | 4.1 | 4.0 | 4.2 | 4.1 | 4.4 |
| 60-64 | 2.1 | 2.2 | 2.3 | 2.6 | 2.5 | 2.8 | 2.7 | 3.0 |
| 65-69 | 1.2 | 1.3 | 1.2 | 1.4 | 1.4 | 1.5 | 1.5 | 1.6 |
| 70-89 | 2.1 | 2.7 | 2.0 | 2.6 | 2.0 | 2.6 | 1.9 | 2.6 |
| 90+ | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 |
| 0-34 нас | 66.2 | 64.6 | 65.3 | 63.9 | 64.8 | 63.4 | 64.5 | 63.1 |
| 35-59 нас | 61.0 | 59.6 | 61.0 | 59.6 | 60.8 | 59.6 | 29.4 | 29.5 |
| 60< нас | 57.1 | 55.9 | 57.2 | 56.2 | 56.9 | 55.7 | 6.2 | 7.3 |

1.4 СУУРИН ХҮН АМЫН ТОО, сумаар, хүйсээр, оны эцэст

| | 2015 | | 2016 | | 2017 | | 2018 | |
|---------------|--------------|-------------------|--------------|-------------------|--------------|-------------------|--------------|-------------------|
| | Бүгд | үүнээс эмэгтэй | Бүгд | үүнээс эмэгтэй | Бүгд | үүнээс эмэгтэй | Бүгд | үүнээс эмэгтэй |
| | тоо | | | | | | | |
| Бүгд | 63125 | 31623 | 66606 | 33304 | 68192 | 34076 | 69560 | 34644 |
| Айраг | 3612 | 1810 | 3738 | 1870 | 3811 | 1892 | 3766 | 1853 |
| Алтанширээ | 1262 | 599 | 1294 | 611 | 1327 | 641 | 1360 | 649 |
| Даланжаргалан | 2680 | 1320 | 2742 | 1352 | 2749 | 1342 | 2895 | 1381 |
| Дэлгэрэх | 1851 | 900 | 1889 | 922 | 1873 | 923 | 1840 | 891 |
| Иххэт | 2039 | 1011 | 2077 | 1035 | 2108 | 1044 | 2112 | 1037 |
| Мандах | 1566 | 757 | 1568 | 765 | 1587 | 783 | 1596 | 774 |
| Өргөн | 1889 | 887 | 1933 | 930 | 2004 | 983 | 2076 | 1009 |
| Сайхандулаан | 1292 | 598 | 1367 | 628 | 1380 | 631 | 1378 | 625 |
| Улаанбадрах | 1431 | 699 | 1474 | 718 | 1470 | 714 | 1482 | 718 |
| Хатанбулаг | 2752 | 1357 | 2941 | 1456 | 2919 | 1435 | 2872 | 1413 |
| Хөвсгөл | 1518 | 743 | 1568 | 767 | 1573 | 769 | 1540 | 737 |
| Эрдэнэ | 2340 | 1079 | 2437 | 1164 | 2378 | 1155 | 2439 | 1153 |
| Сайншанд | 23191 | 11982 | 24059 | 12450 | 24772 | 12803 | 25274 | 9335 |
| Замын-Үүд | 15702 | 7881 | 17519 | 8636 | 18241 | 8961 | 18930 | 13069 |



1.5 СУУРИН ХҮН АМЫН ТОО, сумаар, байршлаар, оны эцэст

| | 2015 | | 2016 | | 2017 | | 2018 | |
|---------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|
| | сумын төвд | хөдөөд | сумын төвд | хөдөөд | сумын төвд | хөдөөд | сумын төвд | хөдөөд |
| | тоо | | | | | | | |
| Бүгд | 48154 | 14971 | 50999 | 15607 | 52333 | 15859 | 53871 | 15689 |
| Айраг | 2367 | 1245 | 2453 | 1285 | 2461 | 1350 | 2401 | 1365 |
| Алтанширээ | 305 | 957 | 298 | 996 | 292 | 1035 | 300 | 1060 |
| Даланжаргалан | 701 | 1979 | 711 | 2031 | 728 | 2021 | 815 | 2080 |
| Дэлгэрэх | 356 | 1495 | 355 | 1534 | 347 | 1526 | 318 | 1522 |
| Иххэт | 1018 | 1021 | 995 | 1082 | 979 | 1129 | 957 | 1155 |
